



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/357

Хэрлэн сум

Прокурорын газарт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.1.15, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Прокурорын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Прокурорын газраас ирсэн хүсэлтийн дагуу прокурорын байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга Ж.Ганбаатарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.НОГСОМЖАВ